



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 02 сарын 07 өдөр

Дугаар 40

Улаанбаатар хот

Г Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх Г
тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 405 дугаар тогтоолоор баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 5.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хөшөөтийн өгөөж” ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2018 оны 01 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлэн 3 жилийн хугацаагаар сунгасугай.

2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, хавсралтад холбогдох тэмдэглэгээг ажлын 15 хоногийн дотор хийлгэхийг “Хөшөөтийн өгөөж” ХЗХ /Г.Удаанжаргал/-нд үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН